

3. АГВААНБАЛДАН

“ДӨРВӨН ТОГТСОН ТААЛЛЫН ЁСНЫ ЯНАГУУХИ ХИЙГЭЭД ҮНЭМЛЭХҮЙН УТГЫГ НОМЛОСОН САЙН НОМЛОЛ ХАВРЫН ОХИН ТЭНГЭРИЙН ДУУЛАЛ ХЭМЭЭХ ОРШВОЙ”

Орчуулсан Р.Алтансүх – Монгол улсын ШУА.ФСЭХ – ийн ЭША

2. Төв үзэлтний ёсны хоёр үнэний ялгаварыг номлох

2.2. Хэтрүүлэгчийн ёсыг номлох

2.2.1. Ер утгыг номлох

2.2.1.1. Өөрийн үндэстийн ёс лугаа адил бусын ялгаварыг ялгахын үүднээс хоёр үнэн ерийн агуулгыг үзүүлэх

Хоёрдугаар, Хэтрүүлэгчийн ёсыг номлохуй дор “Мадхьямакийн үндэс”-ээс «Бурхад бээр номыг үзүүлсэн нь хоёр үнэнд үнэхээр шүтсэн буюу» хэмээх тэргүүтэн таван бадаг хийгээд “Мадхьямакад орохуй”-аас «Бод бүхэн үнэхээр худалыг үзсэнээр бодыг олох хоёр мөн чанар нь баримтлахуй болох» хэмээх тэргүүтэн дөрвөн бадаг ба «мунхаг өвөрчлөн түйтгэрлэх тул янагуухи бөлгөө» хэмээснээс «үзэх тэр тэр ямагыг түүнчлэн үүнээ мэдэхээр» хэмээн хоёр бадаг гарсан. Тэдгээрийн утгыг номлохуйд ер утга хийгээд магадлан шинжлэхүй хоёр. Анхан дор, Өөрийн үндэстийн ёс лугаа адил бусын ялгаварыг ялгахын үүднээс хоёр үнэн ерийн агуулгыг үзүүлэх ба янагуухи хийгээд үнэмлэхүйн ялгалыг тус бүр тусгайлан номлох лугаа хоёр. Анхан дор, “Бодьсавдын явдалд орохуй”-аас «Үнэмлэхүй оюуны явдлын орон бус» хэмээн номлосон ба *судраас* үнэмлэхүй үнэн мэдэгдэхүүн бус хэмээн номлосон хийгээд хамгийг айлдагчийн бэлгэ билгийн вишайгаас /75 б/ нөгчсөн хэмээн номлосон тэргүүтэн үгийн өнгө зарим нэгэнд шүтэж их Ог хэлмэрч бээр үнэмлэхүй үнэн нь мэдэгдэхүүн бус тул үзэгдэл төдийг хоёр үнэний ялгалын шүтээнд таалсан хэмээн алдаршсан хийгээд “Мадхьямакад орохуй”-д «Бод бүхэн үнэхээр худалыг үзсэнээр бод ямагт хоёр мөн чанар нь баримтлахуй болох» хэмээсний таалалд санаж Тансагба заримууд дүрсээс хамгийг айлдагчийн завсар дахь ном бүгдийн мөн чанар нь хоёр үнэний ялгалын шүтээн хэмээн номлосон ба бусад төвдүүд бээр гүтгэн эс шинжлэгдсэн вишай нь хоёр үнэний ялгалын шүтээн хэмээсэн хийгээд үгэнд мунхарсан зарим нэгэн бээр үнэн нь ялгалын шүтээн хэмээсэн ба бас заримууд элдэв шүтэн барилдлага нь хоёр үнэний ялгалын шүтээн хэмээсэн хийгээд Дагцан хэлмэрчийн “Тогтсон таалал бүхнээс мэдэхүй”-д «Хоёр үнэний ялгалын шүтээн нь мэдэгдэхүүн төдийд номлосон» хэмээсний *Тайлбарт* «Янагуух зохис ялдарын мэдэгдэхүүн хийгээд үнэмлэхүй эндүүрлийн ялдарын мэдэгдэхүүн бус ч ялгах үгүйеэ эс ажиглан, эс шинжилсэний ялдар мэдэгдэхүүн төдий энэ нь хоёр үнэний ялгалын шүтээн ямагтад *судраас* номлосон бөлгөө» хэмээн номлосон тэргүүтэн олон боловч “Суртахуун бүхнээс түүсэн”-д *Эцэг хөвгүүн учрахуйн сударыг эшлэн залсанаас* «Энэ мэтээр түүнчлэн заларсан бээр янагуухи хийгээд үнэмлэхүй хоёрыг таалалдаа багтааж, мэдэгдэхүүн ч янагуухи хийгээд үнэмлэхүй үнэн үүнээ

* Академич Г.Лувсанцэрэн багшийн даалгавраар Агваанбалдангийн эд зохиолын Баавгай агсаны орчуулсан хувилбарыг төвд эхтэй нь тулган жигдлэх үүргийг миний бие 2003 онд хүлээсэн юм. Гэтэл Баавгай агсаны тэрхүү орчуулгын эх нь дундаасаа олон хуудас үрэгдсэн байснаас гадна ерөөс ихэд товчилсон, нэр томъёоны оноолт зөрүүтэй, үгүүлбэрийн найруулга бага хийгдсэн зэрэг нь цаг хугацааны хувьд яаруу орчуулсан болов уу гэмээр шинжтэй байсан юм. Тиймээс “Мэргэд гарахын орон”-ны нэр томъёоны санд тулгуурлан уг зохиолыг бүрэн эхээр нь шинээр орчуулж, 2007 онд багшид хүлээлгэн өгч байсан билээ. Энд түүний хэтрүүлэгч төв үзлийн хэсгээс хэсэгчлэн нийтлэж байна.

барагдмуй» хэмээн номлосон мэтээр хоёр үнэний ялгалын шүтээнд мэдэгдэхүүнийг талбихад хэтрүүлэгч, өөрийн үндэст, сэтгэл төдийтөн бүхэн зохилдмуй. Тийн боловч судар үүний үгийн хүчийг унших ёсны ялгавараар хэтрүүлэгч ер бусын ялгавард одох ёс нэгэн буй бөлгөө. Үлгэрлэвээс, номын би хэмээн баримтлахуй бээр орчлонгийн суурь ёзоорын эцэс нь болмуй хэмээн төв үзэлтэн, сэтгэл төдийтөн зохилдох боловч “Хэзээд цогц хэмээн баримтлахуй буй тээээд түүнээ би хэмээн баримтлахуй буй” /76 а/ хэмээхүйн үгийн хүчийг унших ёсонд хэтрүүлэгч, өөрийн үндэст адил бусын ялгавар буй мэтчилэн мөний тул. Мэдэгдэхүүнийг ялгалын шүтээнд талбих нь ч буй хийгээд сууринд бүтсэн тэргүүтнийг хоёр үнэний ялгалын шүтээнд талбих лугаа адил үгүйеэ оюунаа дотогш эргүүлж тийн тонилохуйг чухалчилахуйд үгүй бөгөөс үл болох мэдэж үйлдэх хэрэгтэйг хоёр үнэнд магадлахын утга мөн тул мэдэгдэхүүн хэмээх нэр төдийд ч анхааран авахын анисийг ойлгох нэгэн үндэс буй хэмээн Гүнтан гэгээн бээр номлосоны учир болой. Тиймийн учир судар үүнээ түүнчлэн заларсан бээр хоёр үнэнийг таалалдаа багтаасны учир хамгийг болгоогч хэмээн номлосон бөгөөд *Сайтар номлол алтан эрих* тэргүүтэнд хамгийг болгоогчын бэлгэ чанарын онцгойд үнэмлэхүй, янагуухын байдлыг болгоох хэмээн номлосонд ч ойлгох юм их бөлгөө. Хамгийг болгоогч хэмээх нь олон номыг болгооход эрхин үйлдэх үгүйеэ тонилохуйг чухалчлагч нугууд бээр үгүй бөгөөс үл болох мэдэн үйлдэх зүйл хоёр үнэнийг таалалдаа багтаахын хувиар талбих хэрэгтэй тул. “Шалгадгийн тийн тайлбар”-аас «Түүний тул тэр мөн бүтээгдэхүүнээ болох бэлгэ билгийг тийн шинжлэн үйлдэхээс энэ бээр хорхойн тоог болгоох нь бидэнд нэгээхэн ч чухал хэрэгтэй бус. Авах хийгээд огоорогдохууны тэр ямагт нь арга лугаа сэлтийг зохистой зохиосон. Алин тэр шалгадаг ямагт таалахын хамаг зохистой зохиосон бус болой. Уртыг үзсэн буюу бус ч болох таалахын тэр ямагтыг үзсэн мөн. Хэрэв уртыг үзсэн шалгадаг мөн бөгөөс янагш ирэн хачир шүтэн үйлд» хэмээсэн лүгээ анис нэг болой. Тиймийн тул “Тийн номлол зүрхний чимэг”-ээс «Үүний хамгийг болгоогчыг хоёр үнэнийг болгоох төдийн үүднээс талбих нь ачаръя-гийн /76 б/ таалал бус бөлгөө. Өөрийн ологдохуун хамгийг айлдагч түүний оногдохууныг үзүүлсэн ямагтаар их хөлгөний мөрийн ерийн бие оюуны вишайд ургах нэгэн хэрэгтэй мөн болой» хэмээсэн нь сэтгэл үүсгэхүй тэргүүтэн арван номоор хамгийг айлдагчийг ямар мэтээр бэлгэдэх ёсыг үзүүлэхийн эрхэнд үйлдсэн тул *Алтан эрих* тэргүүтэн лүгээ үл харшилмуй хэмээн мэдэгдэхүй. Бас, мэдэгдэхүүнийг хоёр үнэний ялгалын шүтээн хэмээн эш, зохист ухаан хоёроор бүтээх бөлгөө. Өмнө залсан *Эцэг хөвгүүн учрахуйн сударын* эш ба янагуухи хийгээд үнэмлэхүй хоёрыг зэргээр нэрийтгэлийн шалгадаг мэдэл хийгээд зохис мэдэл хоёрын мэдэгдэхүүн хийгээд шинжлэгдэхүүн мөний хоёр зохист ухаанаар бүтээх хэмээн *Тогтсон тааллын их тайлбарт* номлосон тул. Мэдэгдэхүүнийг хоёр үнэнд ялгах нь ч саармагыг арилгах магад тоо мөн хэмээн төв үзэлтэн, сэтгэл төдийтөн бүхэн зохилдох бөлгөө. Хоёр үнэнд саармаг үгүй хэмээн номлосон судрын эш өмнө залсан нугууд хийгээд үнэн, худал нь янагш чанагш тэвчин харшлах мөн хэмээн хоёр зохист ухаанд шүтэж бүтээхийн учир. “Мадхьямакад орохуйн тайлбар”-аас ч «Түүнээ зовлон хийгээд бүхэн гарахуй ба мөрийн үнэн нь янагуухын үнэний дотор хамаарагдмуй. Түрдэхүй үнэн нь үнэмлэхүйн үнэний өөрийн мөн чанар болой. Түүнчлэн бусад үнэн аль өчүүхэн нэгэн буй тэр ч юу зохистойгоор хоёр үнэний дотор хамаарагдах ямагт хэмээн магадлагдахуй» хэмээн бодьсадвын тавдугаар газраас зовлон тэргүүтэй дөрвөн үнэн хийгээд бэлгэ чанарын үнэн тэргүүтэй найман үнэнийг номлосон нугууд юу зохистойгоор янагуухи ба үнэмлэхүй үнэн хоёрт хурмуй хэмээн номлосоны учир болой. Судар үүнээ арван дөрвөн үнэнийг номлосон бөлгөө. Зовлон, бүхэн гарах, түрдэхүй, мөр дөрөв хийгээд янагуухи ба /77 а/ үнэмлэхүй үнэн хоёр хийгээд бэлгэ чанарын үнэн ба тийн ялгахуй үнэн хийгээд шинжлэхүй үнэн ба бодын үнэн хийгээд махбодын үнэн ба арилсан бөгөөд

үл төрөхүй үнэн хийгээд мөрийн бэлгэ билиг дор орохуй үнэн ба түүнчлэн заларсаны бэлгэ билиг үнэхээр гарахуй үнэн лүгээ арван дөрвийг номлосон тул. *Судар тэр ямагтаас* «Энэ нь зовлон хутагтын үнэн хэмээн үйлдсэнд үнэхээр ямар мэтчилэнд машид мэдэх болой. Энэ нь зовлон бүхэн гарахуй, энэ нь зовлон түрдэхүй, энэ нь зовлонг түрдэх дор одох мөр хутагтын үнэн хэмээн үйлдсэнд үнэхээр ямар мэтчилэнд машид мэдэх бөлгөө» хэмээсэн ба «Тэр бусад амьтан хийгээд бусад бодгальд санаа ямар мэтчилэнд машид баясган үйлдсэнээр янагуухын үнэнийг бас машид мэдэх болой. Арилсан нэгэнд үнэхээр зүтгэснээр үнэмлэхүйн үнэнийг бас машид мэдэх болой. Номын өөрийн бэлгэ чанарыг дотроо багтааснаар бэлгэ чанарын үнэнийг бас машид мэдэх болой. Номын өвөрмөц тийн байгууллыг дотроон багтааснаар тийн ялгахуй үнэнийг бас машид мэдэх болой. Цогц хийгээд язгуур ба төрөн түгэхүйг тийн байгуулснаар адхагын үнэнийг бас машид мэдэх болой. Бие хийгээд сэтгэлд хорлол тэгш бууснаар бодийн үнэнийг бас машид мэдэх болой. Амьтаны үндэсийн завсарыг барилдуулснаар махбодын үнэнийг бас машид мэдэх болой. Хижиг хийгээд огоот энэлсэн бүгд машид амирласнаар арилсан бөгөөд үл төрөхүйн үнэнийг бас машид мэдэх болой. Хоёрдугаар хүмүүнийг илтэд бүтээснээр мөрийн бэлгэ билиг дор орохуй /77 б/ үнэнийг бас машид мэдэх болой. Эгнэгт илтэд бурхан болсон хийгээд бодьсавдын газрын үе зэрэг бүхэн завсар барилдсаныг машид бүтээснээр түүнчлэн заларсаны бэлгэ билиг үнэхээр гарахуй үнэнийг бас машид мэдэх болой» хэмээн номлосоны учир. «Мадхьямакад орохуй»-д *сударыг эшлэн залсанаас* «Нэгэн зорчил дор үнэхээр зүтгэснээр үнэмлэхүйн үнэнийг машид мэдэх болой. Өөрийн хийгээд ерийн бэлгэ чанарыг оносоноор бэлгэ чанарын үнэнийг машид мэдэх болой» хэмээсэн ба «Хижиг өвчний огоот энэлсэн бүгд машид амирласнаар барагдахуй хийгээд үл төрөхүйг мэдэх үнэнийг машид мэдэх болой» хэмээсэн тэргүүтэн энэ лүгээ өчүүхэн адил бусаар гарсан болой. *Шалгадгийн тийнхүү магадлах*-ын үгийн өнгө төдийхөнд шүтэж олон хуучис бээр ангидад гурван зүйлийг аман авах хийгээд зарим нэгэн, янагуухи өөрөөс хоосон ба үнэмлэхүй бусдаас хоосонд аман аваад тэр хоёрыг мөн чанар ангид хэмээн таалсан ба хутагтын оронд ч утгыг өгүүлэгч хоёр бээр хоёр үнэнийг мөн чанар ангид хэмээн таалсан тэргүүтэн олон боловч энэ үесд «Мадхьямакийн гэгээн»-ээс «Хэрэв бод ямагтад түүний мөн чанарын барилдлага мөн буй за, бусдад бус болой хэмээвээс, тэр нь зохистой бус бөлгөө. Түүний мөн чанар нь ангид үгүйн тийн тоо мөний тул бөгөөд тэр нь бод үгүй нүүгүүд ч би үгүй ямагтад сацуу тул харш үгүй ямагт болой» хэмээсэн ба «Бага бодь мөрийн зэрэг»-ээс «*Мадхьямакийн гэгээнээс* нэгэн чанартын барилдлага нь бодод үгүйд ч үл харшлах хэмээн номлосон мэтээр зөв тул ангид юм хоёул бодод үгүй хийгээд алин нэгэн бодод үгүй хоёр хувьд ч нэгэн мөн чанар дор няцалга ангид үл харшлах болой» хэмээн номлосон мэтээр /78 а/ хоёр үнэн нь нэгэн мөн чанар дор няцалга ангид мөн хэмээн хэтрүүлэгч, өөрийн үндэст бүхэн хийгээд сэтгэл төдийтний ихэнхийн таалал зохилдох бөлгөө. «Бодь сэтгэлийн тайлбар»-аас «Янагуухаас нь ангидаар» хэмээх тэргүүтэн өмнө залсан хийгээд «Тааллын тайлбар»-аас «Хуран үйлдэхүй язгуур хийгээд үнэмлэхүй бэлгэ чанар нь нэг хийгээд ангид хагацсан бэлгэ чанар тэр нэг хийгээд ангид ямагтад алин адхаглах тэдгээр ёсчилон бус оршсон мөн» хэмээн номлосоны тул ба зохист ухаанд ч хоёр үнэн мөн чанар ангид бөгөөс үнэнээр үгүйг оносон оюун бээр үнэн хэмээн баримтлахуйг сүрээр үл дарах болон хэтрэх хийгээд дүрс үнэнээр үгүй нь дүрсийн ахуй ёсон бус болон хэтрэх ба дүрсэд үнэнээр бүтсэнийг тийн тасалсан төдийн үгүйеэ хаах тэр нь дүрсийн номын чанар бус болон хэтрэх хийгээд хутагт бурхан бээр дүрсийг үнэнээр бүтсэнд болгоох бөгөөд үнэнээр хоосонг жичэд болгоох болон хэтрэх ба хоёр үнэн нь няцалга нэг мөн бөгөөс эгэл бэртэгчин бээр ч ахуй ёсонг илтэд онох болон хэтрэх хийгээд номын чанар дор зорихоос ч тачаал тэргүүтэн нисванис төрөх болон хэтрэх ба дүрсэд ч дүр адил бусын ялгал үгүй

болон хэтрэх хийгээд дүрсийн ахуй ёсонг шамдалаар эрэх хэрэг үгүй болон хэтрэх лүгээ дөрөв дөрвөн гэм гармуй хэмээн *Тааллын тайлбараас* номлосон нь үүнээ ч хаагдахууны ялгавараас бусдаар адил болой. Пражнямокша бээр зохиосон “Мадхьямакийн увдисын тайлбар”-аас «Нэг бөгөөс янагуухыг тэвчих чилэнд үнэмлэхүйг ч тэвчих ямагтад болмуй. Янагуух ангид чилэнд үнэмлэхүй ч ангид болмуй. Янагуух хир лүгээ сэлт чилэнд үнэмлэхүй ч хир лүгээ сэлт болмуй. 178 б/ Ангид бөгөөс номт хийгээд номын чанар дор ч үл болох бөгөөд хуран үүдсэний бэлгэ чанарыг сүрээр дарах ч үл болох бөлгөө. Мөрийг бясалгах нь ч утга үгүй болон хувирмуй. Тиймийн тул тэр ямагт хийгээд бусдад өгүүлшгүй болой» хэмээн гурав гурван гэмийг номлосон бөгөөд *Тааллын тайлбар* лугаа өчүүхэн адил үгүй үзэгдэвч *мадхьямака* хийгээд *билиг барамидийн сурах бичиг* ба *Их тогтсон таалал* нугуудад тэр хоёрыг товчлон номлосон тул шинжлэх зүйл өчүүхэн нэгэн буй болой. Тэдгээр зохист ухааныг Өөрийн үндэстийн үест дэлгэрэнгүй номлосон тул үүнээ энэ төдийгөөс эс сацруулав. Их шүн нүгүүдэд хоёр үнэнийг нэг хийгээд ангид алин ч бус хэмээн номлосон бүгдийг няцалга нэг хийгээд мөн чанар ангид бусын утганд номлох хэрэг үгүй хэмээн *Бага бодь мөрийн зэрэгт* номлосон мэтээр тэр хоёр нэг хийгээд ангидад явах бөгөөд бэлгэ дор явах хэмээн *Билиг барамидийн сударт* номлосон ба “Үндсэн билиг”-ээс «Ангид утгат бус, нэгэн утгат бус» хэмээсэн мэтээр үнэнээр бүтсэний нэгэн хийгээд ангид алин ч бусын утганд үйлдэх хэрэгтэй хэмээн хэтрүүлэгч, өөрийн үндэст хоёул таалал зохилдох боловч, *Тааллын тайлбараас* тэр хоёрыг нэг хийгээд ангид бус хэмээн номлосныг үнэнээр бүтсэний нэг хийгээд ангид бусын утганд *Мадхьямакийн гэгээнд* тайлбарласан мэтээр Бхававивека багш, шавь хийгээд Шантаракшита багш, шавь тэргүүтэн Өөрийн үндэст нүгүүд таалдаг мөн буй за, ачаръя Буддхапалита хийгээд Чандракирти тэргүүтэн хэтрүүлэгч нүгүүд бээр тэр мэтээр үл таалах бөлгөө. *Тааллын тайлбар* тэргүүтэн үүнээ үзүүлсэн эцсийн хүрдэний үест ном бүгдийг үнэнээр үгүйд үзүүлсэн хэмээн Бхававивека багш, шавь хийгээд Шантаракшита багш, шавь тэргүүтэн өөрийн үндэст төв үзэлтэн нүгүүд таалах бөгөөд хэтрүүлэгч бээр тэр мэтээр үл таалахын учир бөлгөө. 179 а/ “Тогтсон тааллын үндэс”-д «Өөрийн бэлгэ чанараар бүтсэн гурван бэлгэ чанарыг таалах боловч би үгүйд таалан тэр хийгээд тэр үгүй хэмээн номлосон» хэмээсэн тэргүүтэн ба «Чимэг үзэсгэлэнтэйеэ, Тааллын тайлбар, Ланка-д ажирсан судар тэргүүтний утга эрхин, эгэл хоёр хувь нь зэргээр төв, сэтгэлийн ёс» хэмээсэн хийгээд «Анхан, эцэс нь удирдахуй утга, дунд нь магад утга. Ланка-д ажирсан, Тааллын тайлбар, Чимэг үзэсгэлэнтэйеэ таван зүйл судараар үйлдэгч, бусад үгүй, хоосон чанард таалаад сэтгэл төдий гадаад утга үгүй хийгээд зурхэн мөнх. Хотолын шүтээн нь буй хийгээд бусдын эрхэт, огоот бүтсэн нь үнэн. Эцэст гурван хөлгөнд үзүүлсэн тавыг удирдахуй утганд бүтээх» хэмээсэн тэргүүтний утгыг тус тус номлох ёс буйн учир. Ийн хэмээн Дарма-ринчэнгийн “Хоёр үнэний тайлбар”-аас «*Мадхьямакийн гэгээнд* судрын утга хуран үйлдэхүй хийгээд түүний үнэмлэхүй хоёрыг нэгэн хийгээд ангид алинд ч үнэнээр эс бүтсэнд бүтээн номлосон мэтээр Өөрийн үндэст нүгүүд бээр таалах хэрэгтэй амуй» хэмээн номлосоны учир хийгээд Өөрийн үндэстийг тухайлан заасаны хэрэг буй тул. Хоёр үнэний бэлгэ чанар дор ч Дагцан хэлмэрчийн “Тогтсон таалал бүхнээс мэдэхүй”-д «Хоёр үнэний бэлгэ чанар нь зэргээр, эс шинжилсэн эндүүрлийн мэдлийн ялдар олдох олдохуй утга хийгээд үл эндүүрэх хутагтын ухааны ялдар олдох олдохуй утга хэмээн үйлдэх бөлгөө» хэмээсэн ба «Өөрийн үндэстээс доргош лугаа нийлэлдсэн бэлгэ чанар олоныг үүнээ бичих ч бэх цаасны гарлага болой» хэмээсэн тэргүүтэн хоёр үнэний бэлгэ чанарыг өөрийн үндэст лүгээ ихээхэн адил үгүйгээр номлосон буй боловч тэр нь нэрийтгэлийн шалгадгаар бүтсэнийг аман авах төв үзэлтэн мөн бөгөөс өөрийн үндэст төв үзэлтэн мөн болох хэрэгтэй бөгөөд хэтрүүлэгч төв үзэлтэн буюу их төв үзэлтэн мөн бөгөөс нэрийтгэлийн шалгадгаар бүтсэнийг аман үл авах хэрэгтэй

хэмээх тэргүүтэн шалгадгаар бүтэх /79 б/ хийгээд байн чадахгүйг нэгэн дор эндүүрсэн ёс мөн амуй. Түүнийг хорих ёсыг ч *Үндсэн билиг, Мадхьямакад орохуйн хоёр их тийн номлол* хийгээд *Сайтар номлолын зүрхэн* ба ялангуяа *Их үлэмж үзэхүйгээс* тодорхой номлосон тул түүнээ үзэх хэрэгтэй бөгөөд түүгээр ч хялбар ханах үгүйеэ чанад этгээдийг өгүүлэгчийн санааны хэмжээ хийгээд махатма богдын хир үгүй эш ухаанаар хорьсон ёс хоёрыг нягтад мэдэх хэрэгтэй болой. Туйлд хүрсэнийг шинжлэх зохис мэдлийн олох утга тэр нь үнэмлэхүй үнэний бэлгэ чанар. Нэрийтгэлийн шалгадгийн олох утга тэр нь янагуухи үнэний бэлгэ чанар мөн хэмээн төв үзэлтэн хоёул таалал зохилдох бөгөөд *Мадхьямакад орохуй үндэс, тайлбарын* таалал мөн хэмээн бүтээсэн. Тэр бас аравдугаар газараас дорогш тэгш агуулахуй, даган олохуй нэгэн мөн чанар дор эс одсон бэлгэ билиг бээр хоёр үнэнийг тус тус онодог ёсон мэтээр талбисан тул ер нийтийн эрхэнд үйлдсэн амуй. Тухайлж Бурханы бэлгэ билгийн нэгэн агшинаар хоёр үнэнийг тус тус хольцол үгүйеэ болгоох ёсыг хураахын эрхэнд үйлдвээс, туйлд хүрсэнийг шинжлэх зохис мэдэл бээр өөртөө туйлд хүрсэнийг шинжлэх зохис мэдэл болон одохын олох утга тэр нь үнэмлэхүй үнэний бэлгэ чанар. Нэрийтгэлийн шалгадаг бээр өөртөө нэрийтгэлийн шалгадаг болон одохын олох утга тэр нь янагуухи үнэний бэлгэ чанарт талбих нь *Мадхьямакад орохуйн их тийн номлол* хийгээд *Их мянган бэрхийн хураангуй* хоёрын таалал мөн хэмээн Өөрийн үндэстийн үест номлосон тул эс сацруулав. Түүнд ч ба бүрний зарим мэргэд бээр бусдаар номлосон буй ч ер нийтийн хийгээд тухайлсан бэлгэ чанар тэр хоёрыг аман авч болох нь Гүнчэн Жамъяншадвийдорж хийгээд их мэргэн бүтээлч Жанжаа Ролбийдорж хоёрын номлолоос гарсан болой. /80 а/ Хоёр үнэний бэлгэ чанар тэр мэтээр мөн хэмээн хэтрүүлэгч, өөрийн үндэст хоёул зохилдох боловч хоригдохуун нарийн бүдүүний эрхээр шинжлэлийг хэдий чинээ үйлдвээс тэр ямагт чанар буюу үнэмлэхүйг шинжлэхүй дор одох хийгээд хэдий чинээ үйлдвээс тэр ямагт чанарыг шинжлэхүй дор одох үгүйеэ нэрийтгэлийн шинжлэхүйд одохын газрын хуваарь дор хэтрүүлэгч, өөрийн үндэст адил бусын их ялгавар буй бөлгөө. Хэтрүүлэгч бээр ном нугуудад өөр өөрийн нэрийн томъёог зүүх төдийгөөр ханах үгүйеэ томъёо түүнийг зүүх нэрийдлийн шүтээний утга нь ямар мэтээр бүтсэнийг эрж эс олвоос утга түүнийг талбиж эс мэдэх тул тэр мэтээр шинжлэх нь нэрийтгэлийн шинжлэл мөн буй за, үнэмлэхүйг шинжлэхүй хэмээн үл таалах бөгөөд хорлол үгүйн зургаан орохуй мэдлийн аль нэгэнд үзэгдэхийн эрхээр талбисан дор дулдуйдах үгүйеэ вишай тэр өөрийн ер бусын ахуй ёсны зүгээс ямар мэтээр бүтсэнийг эрэх бөгөөс тэр ямагт чанарыг шинжлэхүй дор одмуй хэмээн таалах тул. Хэтрүүлэгч бээр тэр мэтээр эрвээс олдох юм үгүй бөгөөд эс шинжлэн талбих ёсыг *Тодорхой үгстэд* эсрэгцэн хэлэлцэхүйн үүднээс нотлон буулгасан утгыг *Сайтар номлолын зүрхэнд* номлосон мэтээр хураангуй нэгийг байгуулваас, өөрийн аймгийн өвөрмөц өгүүлэгчээс өөрийн үндэст төв үзэлтэн хүртэл зохилдонгуйгаар ном бүгдэд өөр өөрийн нэрийн томъёог зүүсэн утгыг эрвээс олдмуй хэмээн таалхад хэтрүүлэгч бээр тэр нь зохисгүй бөлгөө. Хатууг бэлгэ чанар хийгээд шороог бэлгэдэгдэхүүн хэмээн нэрийдхийн утгыг эрэхийн цагт олдох юм нэгэн буй бөгөөс /80 б/ шороо хийгээд хатуу хоёрыг утга ангидад бүтээх хэрэгтэй бөгөөд тэр мэтээр эс бүтсэний учир бөлгөө. Хатуу бус шороо үгүй учир хэмээн хориж үйлдмүй. Түүнд Өөрийн үндэст тэргүүтэн өгүүлрүүн, шороо хийгээд хатуу нь утга ангидад үгүй боловч хатууг бэлгэ чанар хийгээд шороог бэлгэдэгдэхүүн хэмээн томъёо зүүсний утгыг эрвээс тус тус олдох юм нэгэн буй бөлгөө. Бүтэнцөд Нишада-гийн бие ба Рахугийн толгой хэмээн нэрийтгэлийг үйлдэхийн цагт бие хийгээд толгойноос утга ангид Нишада хийгээд Раху үгүй боловч адхагын ялдар бие хийгээд толгойг ялгахуй шүтээн ба Нишада хийгээд Раху-г ялгалын ном хэмээн нэрийтгэж болохчилон мөн тул хэмээн өгүүлэх чанад этгээдийг өгүүлэгчийн тааллыг байгуулахуй дор “Тодорхой үгст”-ээс «Хэрхэж, бас үлгэрлэвээс Нишада-гийн бие, Рахугийн толгой хэмээн үйлдэхүйд

бие хийгээд толгойноос ангид ялгавар үгүй боловч ялгавар хийгээд ялгаварын шүтээний бод буй түүнчлэнд өөрийн бэлгэ чанараас ангид шороо тэргүүтэн үгүй боловч шорооны өөрийн бэлгэ чанар хэмээхүйд болох болой хэмээвээс» хэмээн номлосон. Түүнд хэтрүүлэгч бээр тэр нь зохисгүй бөлгөө. Ер бие хийгээд толгой хэмээн өгүүлэхийн цагт сонсогч бээр бие хийгээд толгойг ялгахуй шүтээнд барьж хэний бие хийгээд хэний толгой мөн хэмээн мэдэхийг хүсэх бөгөөс үзүүлэгч бээр ч бусдын бие хийгээд толгой мөнийг тодруулахыг хүсэж Нишада-гийн бие ба Рахугийн толгой хэмээн өгүүлэхүйд сонсогчын сэжиг тасрах нь зохистой мөн амуй. Утгын үес үүнээ шороо хийгээд хатуу хоёр нь утга ангидад үгүйн учир шалтгаанаар шороо хийгээд хатуу хоёрыг бэлгэ, бэлгэдэгдэхүүнд талбихын цагт бэлгэ, бэлгэдэгдэхүүний нэрийтгэлийг зүүхийн утгыг эрээд талбих бөгөөс хэдий чинээ шинжилсэн ч шороо хийгээд хатуу хоёр нь барилдлага үгүй, утга үгүй, бусад дор болохоос бус /81 а/ тэр хоёр ялгахуй шүтээн, ялгалын ном дор үл болох тул сонсогч бээр хатууг ялгахуй шүтээнд барьж алины бэлгэ чанар мөн хэмээн мэдэхийг хүсэх цагт үзүүлэгч бээр бусдын бэлгэ чанар мөнийг тодруулахыг хүсээд шорооны бэлгэ чанар мөн хэмээн өгүүлж үл болох бөгөөд тэр мэтээр өгүүлсэн ч сонсогчын сэжгийг арилгах нь зохистой бус тул үлгэрийн утга сацуу бус хэмээн үзүүлэхүйд "Тэр ямагт"-аас «Тэр нь тэр мэтээр бус бөлгөө. Сацуу бусын учир болой. Бие хийгээд толгой хэмээх дуу нугууд нь оюун хийгээд гар тэргүүтэн мэт нэгэн хамт гарсан бод бусдад дулдуйдахуй лугаа сэлтээр орох тул бие хийгээд толгойн дуу төдийхөнд зорьсон оюун төрөх нь байтугай хэний бие, хэний толгой хэмээн нэгэн хамт шинжлэх бод бусдад эгээрэл лүгээ сэлт ямагт болмуй. Нөгөө нь ч ялгавар бусад лугаа барилдааг тодруулахыг хүссэнээр ертөнцийн дохиог даган үйлдсэн, ялгавар Нишада хийгээд Раху хэмээх дуугаар оногчийн эгээрлийг арилган үйлдмүй хэмээхүйд зохистой бөгөөс үүнд хатуу тэргүүтнээс ангид шороо тэргүүтэн үгүй тул ялгавар хийгээд ялгавартын бод нь зохисгүй болой» хэмээн номлосон бөгөөд бас "Тэр ямагт"-аас «Бас бус биеийн шүтээнийг ялангуяад үйлдсэн, ертөнцийн томъёоллын гишүүн болсон, эс шинжилвээс бэтэхүйг шүтэгч Нишада хийгээд толгойн шүтээнийг шүтэгч Раху нь бодгаль тэргүүтэнд ажигласан мэтээр буй тул энэ үлгэр зохистой бус болой» хэмээн ялгахуй шүтээн бие хийгээд толгой ба ялгалын ном Нишада хийгээд Раху нь ертөнцийн нэрийтгэлд ангидад бүтсэн учир тэр хоёр нь шороо хийгээд хатуу хоёрыг нэрийдсэн утгыг эрээд талбих боловч утга ангидад үл болохын үлгэрт эс бүтмүй хэмээн үлгэр эс бүтэхийн өөр нэгэн учир шалтгааныг ч үзүүлсэн тул. /81 б/ Түүнд Өөрийн үндэст өгүүлрүүн, ялгахуй шүтээн бие хийгээд толгой ба ялгалын ном Нишада хийгээд Раху хоёр нь сонсогчын адхагын ялдар ялгахуй шүтээн, ялгалын ном дор нэрийтгэлийг зүүсэн тэр төдий нэгэн буй ч нэрийтгэлийг зүүх түүний утганд шинжилвээс бие хийгээд толгойноос тус тус бүтсэн Нишада хийгээд Раху үл олдох тул тэр хоёр нь утгандаа ялгахуй шүтээн, ялгалын ном дор эс бүтсэн учир шороо хийгээд хатууг нэрийдсэн утгыг эрээд талбисан ч барилдлага үгүй, утга ангидад үл болохын үлгэрт бүтмүй хэмээх таалах ёсыг үзүүлэхүй дор "Тэр ямагт"-аас «Хэрэв тэр төдий нэг зорьсоноор бие хийгээд толгойноос ангидын бусад утга эс бүтсэн тул үлгэр бүтэх ямагт болой хэмээвээс» хэмээн номлосон. Түүнд хэтрүүлэгч бээр буй нь ертөнцийн нэрийтгэлд мөн бөгөөд түүнд нэрийдсэн утгыг эрээд олдохын утганд талбихуй бус буй за, эс шинжилэн талбихуй мөн бөлгөө. Үлгэрлэвээс, таван цогцод шүтээд бодгаль хэмээн нэрийтгэлийг зүүхийн цагт нэрийтгэлийг зүүхийн утга алин мөн хэмээн эрвээс дүрс, сэрэхүй тэргүүтэн ч бодгаль тэр бус бөгөөд дүрс хийгээд сэрэхүй тэргүүтэн таван цогцоос ангид утганд ч бодгаль тэр үл олдох тул нэрийдсэн утгыг эрвээс бодгаль үл олдох буй за. Тийм боловч тэр нь бодгаль өөрийн бэлгэ чанараар эс бүтсэний утга мөн буй за, бодгаль нэрийтгэлд үгүйн утга бус тул цогцод шүтээд бодгалийг нэрийтгэлд буй хэмээн талбиж чадах мэтээр нэрийдсэн утгыг эрэхийн цагт бие хийгээд толгойноос ангид утганд Нишада

хийгээд Раху үл олдох боловч ертөнцийн нэрийтгэлд тэр хоёрыг шүтээн, номд талбиж чадах тул үлгэр бүтэх үгүй болой. Түүнчлэн нэрийдсэн утгыг эрвээс шороо хийгээд хатуу тэргүүтэн бэлгэ, бэлгэдэгдэхүүн нүгүүдийг талбиж эс чадах боловч тэдгээр нь янагш чанагш дулдуйдсаны үүднээс янагуухад буй хэмээн ачаръя Нагаржуна багш, шавь нугууд бээр таалсан болой. Нэрийтгэлд буй дор талбих /82 а/ ёсыг ямагт энэ мэтээр эргэлзээ үгүй зөвшөөх хэрэгтэй бөлгөө. Тэр мэт бусаар нэрийдсэн утгыг эрээд олохын утганд талбих бөгөөс янагуухи нугууд үнэмлэхүйг шинжлэх зохист ухаанаар шинжлэн хүлцэхүйд бүтэх болмуй. Түүгээр бөгөөс үнэмлэхүйгээр бүтсэн болмуй за, янагуухад бүтсэн үл болмуй. Нэрийдсэн утгыг эрвээс биеэс тусгаар Нишада хийгээд толгойноос тусгаар Раху үл олдох төдийхөн бус буй за, дүрс хийгээд сэрэхүй тэргүүтэн алимад номыг ч тэр мэтээр шинжилвээс үл олдох тул тэдгээрийг ч янагуухад үгүй хэмээн зөвшөөх хэрэгтэй бөгөөтөл тэр нь зохистой бус тул нэрийдсэн утгыг эрээд олохын утгыг буй бус хэмээн номлоод, шүтээд нэрийдхийн ёсыг *Мадхьямакад орохуйгаас* мэдэх хэрэгтэй хэмээн *Тодорхой үгстээс* номлосон бөлгөө. "Тэр ямагт"-аас «Тэр нь тэр мэтээр бус бөлгөө. Ертөнцийн нэрийтгэлд тэр мэтээр тийн шинжилгээ эс орохын тул хийгээд ертөнцийн бод нугууд нь үл шинжлэгдэн буйн учир болой. Ямар мэтээр тийн шинжилвээс дүрс тэргүүтнээс ангидаар би үгүй буй за, тийн боловч цогцод шүтээд ертөнцийн янагуухад энэ буй ямагт мөн, түүнчлэнд Раху хийгээд Нишада хоёр ч мөн тул үлгэр бүтэх үгүй болой. Түүнчлэн тийн шинжилвээс шороо тэргүүтэн нүгүүдэд бас хатуу тэргүүтнээс ангидын бэлгэдэхүй шүтээн үгүй бөгөөд бэлгэдэхүй шүтээнээс ангидаар шүтээн үгүй бэлгэ чанар ч үгүй буй за, тэр мэтээр бөгөөс ч энэ нь янагуухад буй бөлгөө. Тиймийн тул ачаръя нугууд бээр янагш яанагш дулдуйдах төдийгөөр бүтэхийн үүднээс бүтсэн хэмээн тийн агуулгыг зохиосон болой. Үүнийг энэ ямагт мэтээр эргэлзээ үгүй аман авч үйлдэх бөлгөө. Тэр мэтээр бус бөгөөс янагуухи нь зохис лугаа төгөлдөр бус буюу, Тиймийн тул /82 б/ энэ ямагтад гагцхүү болмуй за, янагуухад үл болмуй. Зохистоор тийн шинжилвээс ямагт Нишада тэргүүтэн нүгүүд байхгүй нь бус бөлгөө. Тийн бөгөөс юу хэмээвээс, номлон бүхий зохистоор дүрс хийгээд сэрэхүй тэргүүтэн нүгүүд ч буй бус тул тэдгээрийг ч Нишада тэргүүтэн мэтээр янагуухад буй бус ямагтад аман авахуй дор болбоос Тэр мэтээр ч бас бус тул энэ нь буй бус болой» хэмээн номлосон учир. "Мадхьямакад орохуй"-аас «Тэр нь тэр ямагтад буюу ертөнцөд долоон зүйлээр бүтэх бус амуй за. Тийн шинжлэл үгүйеэ ертөнц ямагтаас үүнээ өөрийн гишүүнд шүтэж нэрийдэх мөн. Тэр ямагт нь гишүүнт хийгээд тэр нь хувьт. Тэрэг тэр ямагтыг үйлдэгч хэмээн одоход өгүүлмүй. Төрөлхийтөн нүгүүдийг авагч ямагтад бүтээмүй. Ертөнцөд алдаршсан янагуухыг бүү сөнөөх тун» хэмээсэн ба «Тэдгээр нүгүүдэд тэрэгийн тийн шинжлэлийг үйлдвээс долоон зүйлээр буй бус бөгөөд түүнээс бусдаар болсонд ертөнцөд алдаршсаны үүднээс буй мөн» хэмээх тэргүүтэн номлосон тул. Тийн бөгөөс "Хоёр үнэн"-ээс «Ямар мэтээр үзэгдэхчилэн мөн чанарын тул үүнд шинжлэл эс орох болой. Тийн шинжлэн үйлдвээс утга бусдад одох тул» хэмээсэн ба *Тайлбараас нь ч* «Юун бөлгөө, янагуухи нь ямар мэтээр үзэгдэхчилэн мөн бөгөөд түүнд ийн хэмээн номлосон шинжлэлийн орон үгүй ямагт болой» хэмээсэн ба «Бид нар нь үүнд шинжлэн үл үйлдэх буй за, шинжлэн үйлдэхүй дор нь хорин үйлдмүй» хэмээн номлосон мэтээр өөрийн үндэст төв үзэлтэн нүгүүд ч янагуухад буйг зохист ухаанаар шинжлэх утганд талбихыг хорих тул нэрийтгэлд буйг /83 а/ зохист ухаанаар шинжлэх утганд үл талбих нь хэтрүүлэгчийн ялгалын номд хэрхэн болох хэмээвээс, гэм үгүй бөлгөө. хэтрүүлэгч, өөрийн үндэст хоёул бээр нэрийтгэлд буй нугуудыг үнэмлэхүйг шинжлэн үйлдэх зохист ухаанаар шинжлэн хүлцэхүйд үл талбин таалдаг нь зохилдох боловч өмнөх мэтээр үнэмлэхүйн шинжлэлд одохын зааг нь адил бусын учир бөлгөө. Нэрийтгэлийг зүүсэн төдийгөөр ханах үгүйеэ нэрийтгэлийг зүүхийн утга нь алин мөн хэмээн шинжилвээс үнэмлэхүйг шинжилсэн болмуй хэмээн хэтрүүлэгч бээр

таалах бөгөөд Өөрийн үндэст бээр тэр мэтээр үл таалах бөлгөө. Өөрийн үндэст бээр ном нугуудад тэр хийгээд түүний нэрийн томъёог зүүсэн төдийгөөр нэрийтгэлд буй хэмээн талбих бөгөөс цагригласан эрээн дээсийг могой болой хэмээн нэрийтгэлийг зүүсэн төдийгөөр суурь түүнээ могой буй болох хийгээд мануухайг хүмүүн ба зэрэглээг ус хэмээн нэрийтгэлийг зүүсэн төдийгөөр тэр хийгээд түүний утгыг үйлдэх болох хэрэгтэй бөгөөтөл тэдгээр нь зохисгүй тул хэмээхүйд хэтрүүлэгч бээр цагригласан могойд могойн нэрийтгэлийг зүүсэн утгыг эрэхийн цагт олдох юм буй бөгөөд цагригласан эрээн дээсэнд могойн нэрийтгэлийг зүүсэн утгыг эрэхийн цагт олдох юм үгүйн ялгавар зохисгүй бөлгөө. Тэр хоёрт могойн нэрийтгэлийг зүүсэн утгыг эрвээс олдох юм үгүй нь сацуу боловч цагригласан могойн газарт могой буй бөгөөд цагригласан эрээн дээсний газарт могой үгүйн ялгавар зохисгүй бус бөлгөө. Цагригласан могойнд могойн нэрийтгэлийг зүүхэд нэрийтгэлийн шалгадаг бусад бээр хорлол үгүй хийгээд тэр ямагт чанар дор ёсчлон шинжлэх зохист ухаанаар үл хорлох ба нэрийтгэлийн мэдэлд тэр мэтээр үзэгдэх лүгээ гурван ялгавараар суурь түүнээ могой буй хэмээн талбимуй. Эрээн дээсийг могой хэмээн нэрийтгэлийг зүүвээс нэрийтгэлийн шалгадаг бусад бээр /83 б/ хорлох учир суурь түүнээ могой буй хэмээн эс талбих тул хэмээн таалмуй. Ийн хэмээн "Бодь мөрийн зэрэг"-ээс «Түүнд нэрийтгэлд буй хэмээн таалах хийгээд үгүй хэмээн таалах нь юуны үүднээс талбисан мөн хэмээвээс, нэрийтгэлийн мэдэл дор алдаршсан мөн хийгээд ямар мэт алдаршсан утга түүнд нэрийтгэлийн шалгадаг бусад бээр хорлол үгүй ба тэр ямагт чанарт буюу өвөрчлөн буй, эсэхийг ёсчлон шинжлэх зохист ухаанаар хорлол үл буух нэгэн нь нэрийтгэлд буй хэмээн таалах бөгөөд тэдгээрээс нягтсан нь үгүй мөн хэмээн таалмуй» хэмээн номлосон болой. *Эс шинжлэн талбих* хэмээх нь ч нэрийтгэлийг зүүсний утга аль мөн хэмээн үл эрэх мөн буй за, шинжлэлийг ашид эс үйлдэх бус бөлгөө. Цагригласан могой тэр нь могой мөн үү бус уу, суурь түүнээ могой байна уу үгүй юу хэмээн эс шинжлэх бөгөөс суурь түүнээ могой буй хэмээн талбиж үл чадахын учир хийгээд тэр мэтээр эрсэн төдийгөөр нэрийдсэн утгыг эрсэнд эс болохын учир болой. Хоёр үнэний бэлгэ чанар *Мадхьямакад орохуй үндэс, тайлбараас* номлосон тэр нь адхагт, адхаг үгүй мэдэл ерийн снوخ ёсон мэтээр талбисан мөн амуй. Адхаг үгүй мэдлийн үзэх ёсон мэтээр талбих бөгөөс, өөрийг илтэд онох шалгадгаар хоёр үзэгдэл сүйдсэн ёсоор оногдохуй тэр нь үнэмлэхүй үнэний бэлгэ чанар. Өөрийг илтэд онох шалгадгаар хоёр үзэгдэл лүгээ сэлтийн ёсоор оногдохуй тэр нь янагуухи үнэний бэлгэ чанар хэмээн үйлдэх бөлгөө. Энэ нь *Эцэг хөвгүүн учрахуй* хийгээд *Үл барагдах оюут* тэргүүтэн олон судрын таалал мөн бөгөөд ачаръя Шантидева хийгээд Бхававивека ба зүүн гурван өөрийн үндэст төв үзэлтэн тэргүүтэн олон мэргэдийн таалал мөн хэмээн өмнө өөрийн үндэстийн үест дэлгэрэнгүй номлосон тул үүнд эс сацруулмуй. /84 а/ Түүн лүгээ үл зохилдон төв үзэлтэнд үзэгдэл, хоосон хоёрын чуулганыг үнэмлэхүй үнэн хэмээн таалах Илбэ зохис бүтээгч буюу Өөрийн үндэст хийгээд үзэгдэлд туурвилгыг тасалсан төдийг үнэмлэхүй үнэнд таалах машид эс оршигч буюу хэтрүүлэгч хоёрт ялгах тэргүүтэн хуучсын олон тааллыг түрдэх, талбих нь дэлгэрэнгүйгээр махатма богдын зарлигаас гарсан болой. Хоёр үнэний бэлгэ чанарыг энэ мэтээр талбихад хэтрүүлэгч, өөрийн үндэстэд адил бусын ялгавар үгүй боловч хоёр үнэн нь илт шалгадаг мэдлийн үлигдэхүүн мөн, бус хийгээд илт болсон, эчнээ болсонг талбих ёс ба илтийн бэлгэ чанар хийгээд дуун номлол ба адхагаас хагацсан болох хэрэгтэй, хэрэггүй хийгээд илт бодтой, илт нэрийдсэний ялгавар тэргүүтэнд хэтрүүлэгч, өөрийн үндэст хоёр таалал үл зохилдох олон буй нугуудыг бусдаас мэдэх хэрэгтэй бөгөөд "Судар"-аас «Үнэмлэхүй үнэн нь алинд сэтгэлийн гүйдэл бас үгүй бөгөөс үсэг нүгүүд өгүүлэх юун хэрэг» хэмээн номлосон үүгээр тэр ямагт чанарыг илтэд болгоох бэлгэ билгийн ялдар хоёр үзэгдэл сүйдэх ёсыг үзүүлсэн

хэмээн хэтрүүлэгч, өөрийн үндэст зохилдох боловч *сэтгэлийн гүйдэл* хэмээхийг адхаг, адхаг үгүйн алинд үйлдэх нь адил бус хэмээн өмнө номлон дууссан.

Хоёр үнэний дуун номлолд, ер үнэмлэхүйд *Бадрангуй онолоос* гурван номлох ёсон гарсан мэтээр *Их үлэмж үзэхүйд* ч номлосон тул утга түүнээ хэтрүүлэгч, өөрийн үндэст хоёул зохилдох бөгөөд үнэмлэхүйгээр үгүй хэмээхийн үнэмлэхүйд ч хоёр номлох ёсон гарсан мэтээр хэтрүүлэгч, өөрийн үндэст хоёул зөвшөөдөг бөлгөө. "Мянган бэрхийн хураангуй"-аас «Үнэмлэхүйгээр хэмээхийн үнэмлэхүйд талбих хуваарь хоёр буйг хэтрүүлэгч, өөрийн үндэст хоёрын үест мэдэх нь анис их бөлгөө» хэмээн номлосон болой. Эдгээрийг өөрийн үндэстийн үест номлон дууссан. Тийм боловч /84 б/ үнэмлэхүй үнэн хэмээхийн үнэмлэхүйн дуун утганд хэтрүүлэгч, өөрийн үндэст адил бус бөлгөө. Өөрийн үндэст бээр өмнө номлосон мэтээр дээд хэмээхийг үнэмлэхүйг онох тэгш агуулахуй цувирал үгүйн бэлгэ билиг хийгээд *утга* хэмээхийг түүний вишайд номлох боловч "Тодорхой үгст"-ээс «*Утга* ч тэр мөн бөгөөд дээд ч тэр мөн тул дээд *утга* болой. Тэр ямагт үнэн мөн тул дээд *утгын үнэн* болой» хэмээн номлосон мэтээр хэтрүүлэгч бээр *утга* хийгээд дээд хоёрыг дээд *утгын үнэн* ямагтад таалах бөлгөө. "Үндсэн билгийн тийн номлол"-оос «Бусад нугууд дээд нь тэгш агуулахуй цувирал үгүйн бэлгэ билиг хийгээд *утга* нь түүний вишай хэмээн номлодог мэтээр үл таалах буй за, *утга* хийгээд дээд хоёрыг дээд *утгын үнэн* ямагтад таалдаг болой» хэмээсэн ба "Их мянган бэрхийн хураангуй"-аас «Өөрийн үндэст төв үзэлтэн олонхи нугууд дээд хэмээхийг үнэмлэхүйг болгоох тэгш агуулахуй цувирал үгүйн бэлгэ билиг хийгээд *утга* хэмээхийг түүний вишайд номлох боловч» хэмээснээс «*Утга* тэр ямагт нь дээд ахуй ёсон буюу үнэхээр мөн тул дээд *утга* хийгээд орших ёс бусдад орших бөгөөд үзэгдэх ёс бусдад үзэгдэхийн үүднээс ертөнцөд хуурмаг бусаар, түүнээс няцсан хуурмаг үгүй мөний учир үнэн болой» хэмээн номлосон тул. Тиймийн тул энэ үест номын чанар тэр нь мэдэн үйлдэхийн дээд утга мөн тул дээд үнэн хэмээн үйлдэх бөгөөд *Бадрангуй онолын* номлох ёсон анхдугаар лугаа адил болой. Тэр ямагт нь үзэгдэх ёс хийгээд орших ёс зохилдсон хуурмаг үгүй мөн тул үнэн хэмээгдэхүй бөгөөд түүний үнэний утгыг хуурмаг үгүйд үйлдэх нь олон судар, шастарын таалал мөний учир бөлгөө. "Үндсэн билгийн тийн номлол зохист ухааны далай"-аас «Үнэмлэхүй үнэний үнэн болох ёс нь хуурмаг үгүй мөн бөгөөд тэр бас орших ёс нь бусдад орших бөгөөд үзэгдэх /85 а/ ёс нь бусдад үзэгдээд ертөнцөд хуурмаг үгүйн тул үнэмлэхүйн үнэнд ертөнцийн нэрийтгэлийн эрхээр буй хэмээн талбих төдий мөн бөлгөө. Ухааны жаран шүлэгтийн тайлбараас, хэрэв тэр мэтээр бөгөөс хэрхэн муу гаслангаас нөгчихүйг үнэмлэхүйн үнэнд номлох хэмээвээс, түүний мөн чанар дор ертөнцөд хуурмаг үгүйн тул ертөнцийн нэрийтгэл ямагтаар түүнийг үнэмлэхүйн үнэнд номлосон болой. Хуран үүдсэн хуурмаг алин мөн тэр нь үнэмлэхүйн үнэн бус болой. Гурван үнэн нь хуран үүдсэн ямагт мөн тул өвөрчлөн үгүйчлэнд үзэгдэх учир нялхас нугуудыг хууран үйлдэх ямагтын тул янагуухын үнэнд тийн агуулмуй хэмээн муу гаслангаас нөгчихүйг янагуухын үнэний ялдар агуулахуй дор тийн бөгөөс үнэмлэхүйн үнэнд зохисгүй болой хэмээсний хариуд номлосон болой. Тийн болбоос Ухааны жаран шүлэгтээс, муу гаслангаас нөгчихүй нь гагцаар үнэн, ялгуусан нугууд бээр хэзээ номлосон, тэр цагт үлдвэр буруу бус хэмээн мэргэн хэн бээр адхаглан үйлдэх хэмээн муу гаслангаас нөгчихүй гагц үнэн буй за, бусад нугууд үнэн бус хэмээн номлосныг хэрхэн удирдах хэмээвээс, үүний хариу нь Ухааны жаран шүлэгтийн тайлбараас, тийн бөгөөс ялж төгс нөгчсөн бээр, аягха тэхимлиг нугууд аа, дээд үнэн энэ нь нэгэн бөлгөө. Энэ мэт мөн бөлгөө, хуурмаг үгүйн номт муу гаслангаас нөгчихүй болой хэмээн алин номлосон тэр нь ямар мэт хэмээвээс, ямар мэтээр хуран үүдсэн нь буруу үзэгдсэнээр нялхас нугуудыг хууран үйлдэх мөн түүнчлэнд муу гаслангаас нөгчихүй нь бус бөлгөө. Үргэлжид төрөх үгүйн өвөрчлөнгөөр мөн чанар ямагтад орших ямагтын учир болой. Тэр нь нялхас нугуудад ч хуран үүдсэн мэтээр төрөхүйн мөн чанарт хэзээ ч үл үзэгдмүй.

Тиймийн тул /85 б/ муу гаслангаас нөгчихүй нь эгнэгт муу гаслангаас нөгчихүй ямагтад орших учир ертөнцийн нэрийтгэл ямагтаар дээд үнэнд номлосон буй за хэмээн хуурмаг үгүй нь үнэн хэмээн номлосны утга хийгээд тэр бас нэрийтгэлийн эрхээр мөн хэмээн номлосны учир. Судрын аймаг ямагтаас ч хуурмаг үгүйн номт хэмээн үнэний утгыг түүнд номлосны учир хийгээд хуран үйлдсэн бүхэн нь худал, хуурмагын номт хэмээн худалын утгыг хуурмаг дор номлосноос ч үнэний утга нь хуурмаг үгүй мөн хэмээн мэдэх болой» хэмээн номлосны учир. Тиймийн тул худал хийгээд үнэний утгыг хуурмаг хийгээд хуурмаг үгүйд үйлдэх бөгөөд хуурмаг, хуурмаг үгүй хоёрыг ч өөрийг илтэд үзэх оюуны ялдар өвөрчлөнгөөр эс бүтсэнчлэн өвөрчлөнгөөр бүтсэнд үзэгдэх хуурмаг буй эсэхийн үүднээс талбих бөлгөө. “Үндсэн билиг”-ээс «Ялж төгс нөгчсөн бээр ном алин нэгэн хуурмаг, тэр нь худал хэмээн номлосон. Хуран үйлдсэн бүхэн хуурмагын ном, тиймийн тул тэдгээр нь худал мөн» хэмээсний номлогдохуун ёзоорын Судараас «Аягха тэхимлиг нугууд аа, хуран үүдсэн хуурмагын номт алин мөн тэр нь худал мөн бөгөөд хуурмаг үгүйн номт муу гаслангаас нөгчихүй алин мөн тэр нь дээд үнэн болой» хэмээн номлосон бөгөөд түүний тайлбар нь “Тодорхой үгстээс”-ээс «Хуран үйлдсэн бүхэн худал бөлгөө, хуурмагын номт мөний учир. Зэрэглээний ус мэт болой. Алин нэг үнэн тэр нь хуурмагын номт бус бөлгөө. Үлгэрлэвээс, муу гаслангаас нөгчихүй мэт болой» хэмээсэн ба “Бага бодь мөрийн зэрэг”-ээс «Муу гаслангаас нөгчихүй нь үнэмлэхүй үнэн хэмээн Ухааны жаран шүлэгтээс номлосон мэтээр мөн тул түүнийг илтэд үзэх оюун түүний ялдар өвөрчлөнгөөр эс бүтсэнчлэн түүнд үзэгдэх /86 а/ хуурмаг үгүй амуй. Үлдвэр хуран үйлдсэн нүгүүд нь өөрийг илтэд үзэх оюуны ялдар өвөрчлөнгөөр эс бүтсэнчлэнд үзэгдэх хуурмаг буй тул» хэмээн номлосон тул. Өмнө залсан судар түүнийг бага хөлгөн өөрт нь алдаршсан судар хэмээн Билгийн зул тэргүүтнээс номлосон бөгөөд түүний утгыг өмнөх мэтээр төв үзэлтэн бээр тайлсанд ширваны хоёр аймаг бээр тэмцэлдэх ёсон хийгээд ширваны аймгийн өөрийн ёсонд судар түүний утгыг номлох ёс тэргүүтнийг мэдэх хэрэгтэй бөлгөө. хэтрүүлэгч, өөрийн үндэст хоёр бээр ч судар түүнийг бага хөлгөний аймаг савын шүн үг мөн хэмээн аман авах нь зохилдох боловч бага хөлгөний аймаг сав мөн, бусад таалал үл зохилдох бөлгөө. Бхававивека бээр судар түүнийг бага хөлгөний сударт таалдаггүй хэмээн Мадхьямакийн магадлан шинжлэл-д номлосны учир хийгээд Өөрийн үндэстээс дорогшид бээр бага хөлгөний судраас номын би үгүйг эс үзүүлсэн хэмээн таалдаг тул. Үүнд бас тэмцлийн хариу тэргүүтнийг Үндсэн билгийн долдугаар маш үйлдэхүйн тайлбар Билгийн зул хийгээд Мадхьямакад орохуйн өөрийн тайлбар-т гарсан утгыг Мадхьямакад орохуйн тийн номлол ба Мадхьямакийн магадлан шинжлэл-ийн бүтэх утгын үест үзэгдэхүй. Бас бус, Өөрийн үндэст бээр түрдэхүй үнэнийг янагуухи үнэнд таалдаг хэмээн алдаршсан мэтээр бөгөөс өмнө залсан судараас номлосон үнэн, худалын утгыг огоот алдаршсан мэтээр бус, бусдаар номлох хэрэгтэйг мэдэгдэхүй. Хэрэв өөрийг илтэд үзэх оюуны ялдар өвөрчлөнгөөр эс бүтсэнчлэн өвөрчлөнгөөр бүтсэнд үзэгдэх хуурмаг буй эсэхээр хуурмаг хийгээд хуурмаг үгүй хэмээн талбих бөгөөс үйлийн үрийн нарийн барилдлага ба хамгийг болгоогч тэргүүтнийг илтэд үзэх оюуны ялдар үнэн үзэгдэл буй болох амуй. Тийм бөгөөс тэдгээр нь бурхан ямагтын илтийн /86 б/ явдлын орон бус болмуй хэмээвээс, гэм үгүй бөлгөө. Амьтны үндсэнд хамгийг болгоогч хийгээд үйлийн үрийн нарийн барилдлагыг илтэд үзэх оюун буй боловч тэдгээрийг илтэд онох оюун үгүй хэмээн урд Судрын аймагтны үест номлосон мэтээр мөн тул. Эс бөгөөс бурхан ямагтын илтийн явдлын орон мөн болбоос худал ба хуурмагын ном бусаар түгэх болохын учир ба үйлийн үрийн нарийн барилдлага хийгээд хамгийг болгоогч тэргүүтнийг үнэн ба хуурмаг үгүйн ном хэмээн зөвшөөх хэрэгтэй болохын учир болой. Үүнээс эмээж зарим нэгэн бээр өөрийг илтэд үзэх оюунд үзэгдэх мэтээр ахуй ёсны эцэсд бүтэх, эс бүтэхээр хуурмаг үгүй хийгээд хуурмагт талбих нь ч урд

залсан *Бага бодь мөрийн зэрэг*-ийн шүн лүгээ харшлах болох тул зохисгүй болой. Зарим нэгэн бээр амьтны үндэсийн хамгийг болгоогч мөнх бусыг илтэд оносон йогын илт тэр бээр хамгийг болгоогчыг илтэд үзэх боловч хамгийг болгоогчыг илтэд эс онох нь зохисгүй бөлгөө. Йогын илт мөн болбоос аль үзсэнээ магадлахаар түгэх тул хэмээвээс, нотлол нь эс бүтэх бөлгөө. Эс бөгөөс энэ үест йогын илтийн олонхи нь үнэн үзэгдэлт мөн тул тэдгээр бээр үнэн бүтсэнийг онох болон хэтрэх учир. Бас бус, "Ухааны жаран шүлэгтийн тайлбар"-т «Юу, муу гаслангаас гэтлэхүй бас янагуухи үнэн мөн буюу хэмээвээс энэ нь түүнчлэн бөлгөө» хэмээсэн ба «Түүний тул муу гаслангаас гэтлэхүй нь янагуухын үнэнд огоот ажиглагдахуй ямагт мөн болой» хэмээн номлосны утга нь муу гаслангаас гэтлэхүй үнэмлэхүй үнэн буй хэмээн талбих нь ч янагуухи үнэн нэрийтгэлийн мэдэлийн ялдар буй төдийд талбихын /87 а/ утга мөн хэмээн *Бага бодь мөрийн зэрэгт* номлосон бөгөөд "Хоёр үнэний өөрийн тайлбар"-т «Үнэмлэхүйд үнэн тул үнэмлэхүй үнэн болой» хэмээн номлосон нь ч зохис мэдлийг үнэмлэхүй хэмээн номлосны үнэмлэхүй түүний ялдар хуурмаг үгүйд үйлдэх хэмээн тэр ямагтаас болой. Бас "Тэр ямагт"-аас «Үнэмлэхүй нь үнэмлэхүйд үнэн бус бөгөөс янагуухи нь янагуухад үнэн бус болой хэмээн өгүүлэх нь таалал мөн бөгөөд урд нь урдад эс бүтвээс хойд нь хойдод эс бүтмүй хэмээн өгүүлвээс, үнэнийг хаах нь үнэнээр эс бүтсэн бөгөөс хорихуй шүтээн номт нугууд үнэнээр бүтсэнд болох болой хэмээсэн болох бөлгөө. Хорихуй шүтээн номт дор үнэнийг хаасан төдийг үнэмлэхүй үнэн хэмээн талбих учир хийгээд номт нугууд янагуухад эс бүтсэн хэмээн орхих нь худалаар эс бүтсэн хэмээн орхихын тул болой. Тийм бөгөөс машид барилдлага үгүй болох бөлгөө. Үзэгдэл номт нугууд үнэнээр бүтсэнд үгүй нь үнэнээр эс бүтсэн ямагтаар хорихуй шүтээн нугуудыг худал хэмээн бүтээх хэрэгтэй тул болой» хэмээн ч номложихуй. Янагуух үнэний дуун утганд ер бөгөөс янагуухын үгний гарал *samvrti* хэмээхүй нь боох хийгээд онгойх тэргүүтэн олон утганд орох бөгөөд ялангуяа "Тодорхой үгст"-ээс «Бүхэнээ түйтгэрлэх тул янагуухи бөлгөө. Үл мэдэхүй нь бодын тэр ямагт чанарыг бүхэнээ бүрхэн үйлдэхийн тул янагуухи хэмээн үйлдмүй. Эсвээс янагш чанагш шүтэхийн учир янагуухи бөлгөө. Янагш чанагш шүтэх ямагтын учир хэмээн үйлдсэний утга болой. Эсвээс янагуухи нь дохио бөлгөө. Ертөнцийн нэрийтгэл хэмээсний томъёо үг болой. Тэр ч өгүүлэхүй хийгээд өгүүлэгдэхүүн ба /87 б/ мэдэл хийгээд мэдэгдэхүүн тэргүүтний бэлгэ чанартан болой» хэмээн номлосон мэтээр гурав буй амуй. Үнэний үгний гарал *satya* хэмээх нь ч "Амаракоша"-аас «Үнэн хийгээд сайн ба буй хийгээд сайшаахуй ба тахих зохист нугуудаас арилсан» хэмээн таван утганд орохоор номлосон бөгөөд дээд хийгээд зохист ухаанаар үлихүйд орох хэмээн номлосон ч буй болой. Тэдгээрээс янагуухи үнэн алины ялдар үнэн хэмээн талбихын янагуухи нь гурван янагуухын анхдугаар, тэр ямагт чанарыг үзэхүй дор түйтгэрлэн үйлдэх үнэн хэмээн баримтлахуйн мунхаг мөн амуй. Дүрс тэргүүтэн ном нугууд нь мунхаг түүний ялдар үнэн учир янагуухи үнэн хэмээх бөлгөө. *Ланкад ажирсан хийгээд Мадхьямакад орохуй үндэс, тайлбар* ба Жнянагарбхагийн *Хоёр үнэн*-ээс ч тэр мэтээр номлосон тул утга үүнээ хэтрүүлэгч, өөрийн үндэст үл зохилдохуй үгүй бөгөөд "Их тайлбар зохист ухааны далай"-аас «Янагуух нь аль, үнэн нь аль хэмээвээс, түүнд дүрс тэргүүтэн нүгүүдийг янагуухи алины ялдар үнэнд талбихын янагуухи нь ном нугуудад өвөрчлөнгөөр бүтсэн өөрийн мөн чанар үгүй бөгөөтөл буй хэмээн гүтгэх мунхаг мөн бөлгөө. Бодод үнэнээр бүтсэн байхгүй тул үнэн хэмээн талбих нь оюуны ялдар мөн бөгөөд үнэнд баримталсан бус оюуны ялдар үнэн хэмээн талбихуй үгүй тул» хэмээн номлосны учир. Бас бус, *Мадхьямакад орохуйн тайлбараас* нисванист мунхагын эрхээр янагуухи үнэнийг талбимуй хэмээн номлосон нь янагуухи үнэн хэмээх үгийн үнэн нь утгандаа үнэнээр бүтсэнд үл үйлдэх тул оюуны ялдар мөн бөгөөд тэр бас бусад оюуны ялдар үнэн мөн хэмээн /88 а/ талбихуй үгүй тул үнэнд баримтлах мунхагын ялдар үнэнд талбихын утга

мөн бөлгөө. Бас нисванист мунхагыг тэвчсэн ширван, брадикабудда, бодьсадва нугуудад хуран үйлдсэн нүгүүд янагуухи төдий хэмээн номлосон нь тэр гурван бодгалийн ялдар хуран үйлдсэн нүгүүд янагуухи хийгээд хоёр үнэний дотороос янагуухи төдийд талбихын утга мөн буй за, янагуухи үнэн бусаар янагуухи төдий мөн хэмээсэн утга бус бөлгөө. “Бага бодь мөрийн зэрэг”-ээс «Үүнд Мадхьямакад орохуйн тайлбараас, тэр мэтээр нэжгээд нэгэн орчлонгийн гишүүнээр огоот хураагдсан нисванист мунхагын эрхээр янагуухын үнэнийг тийн агуулмуй. Тэр бас ширван хийгээд брадикабудда ба бодьсадва нисванист мунхагыг тэвчсэн, хуран үйлдсэнийг дүрс хөрөг тэргүүтэн буй ямагт лугаа адилаар болгоох нугуудад нь засдаг өвөрчлөн мөн буй за, үнэн нь бус бөлгөө. Үнэн хэмээн илтэд хөөрөмшихүй үгүйн учир болой. Нялхас нугуудад нь хууран үйлдэгч мөн амуй. Түүнээс бусад нугуудад нь илбэ тэргүүтэн мэтээр шүтээд барилдаж болсон ямагтаар янагуухи төдийд болмуй хэмээн номлосон нь янагуухи үнэнд буй хэмээн талбидаг нугууд нь мунхагаар буй хэмээн талбидаг ба нисванист мунхагыг тэвчсэн ширван, брадикабудда, бодьсадвайн ялдар янагуухын үнэнийг үл талбимуй хэмээн үзүүлсэн бус болой. Үүнд анхдугаарын учир шалтгаан нь урд номлосон мэтээр нисванист мунхаг нь үнэнд баримтлахуй мөн тул түүний барьсан утга нэрийтгэлд ч буй бусын учир хийгээд янагуухи үнэн мөн бөгөөс нэрийтгэлд буйгаар түгэхийн учир болой. /88 б/ Тиймийн тул ном нугуудыг янагуухад буй хэмээн талбихын талбих газрын янагуухи мөн бөгөөс нь нисванист мунхагыг янагуухи хэмээн үйлдсэн тэр бус болох хэрэгтэй болой. Хоёрдугаарын учир шалтгаан нь нисванист мунхагын янагуухыг тэвчсэн нүгүүдэд алины ялдар үнэнд талбихын үнэн хэмээн шунахуйн янагуухи үгүйн учир шалтгаанаар хуран үйлдсэн нүгүүд нь тэдгээрийн ялдар үнэн бусаар бүтсэн буй за, янагуухи үнэн бусаар эс бүтсэний учир болой. Тиймийн тул тэдгээрийн ялдар хуран үйлдсэн нүгүүд янагуухи төдийд номлосон нь түүний ялдар янагуухи хийгээд хоёр үнэний дотороос үнэнд талбихуй үгүй тул төдий хэмээх дуугаар үнэнийг таслах буй за, янагуухи үнэнийг үл таслах тул янагуухи төдий хийгээд янагуухи үнэн хошоодыг номлосны тааллыг түүнчлэн мэдэгдэхүй» хэмээн номлосны учир хийгээд Үндсэн билгийн их тайлбар-аас ч энэ ямар мэтчлэнд номлосны учир ба “Тийн номлол тааллыг машид тодруулагч”-аас ч «Алины ялдар үнэн бусын бодгаль нь гурав бөгөөд ширван, брадикабудда, бодьсадва болой. Тэр бас ширван, брадикабудда, бодьсадва алин мөнд үл үйлдсэн тул ялгаварыг өгүүлэх нь хуран үүдсэн бүхэн дүрс хөрөг мэтчилэн өвөрчлөнгөөр хоосон ч түүнээ үзэхээр илтэд онох нь нэгэн ялгавар болой. Тэр төдий нь долдугаар газрын бодьсадваас дорогш хийгээд ширван, брадикабуддын хутагт суралцагч нугуудад ч буй тул түүнийг таслахын тулд гурван бодгалийг мунхагыг тэвчсэн хэмээн номлосон тул арилсан газрын бодьсадва хийгээд ширван, брадикабуддын архад хоёрыг хэлэх бөлгөө. Тэр гурвын ялдар үнэн бус болой. Алимад үнэн бус нь тэр бас хэмээхүй /89 а/ гадна, дотны ном нугууд болой. Үнэн бусын учир шалтгаан нь үнэн хэмээн хөөрөмшихүй буюу үнэн хэмээн шунахуй үгүйн учир бөлгөө. Үнэнд баримтлахуй мунхагыг барсаны учир болой. Тиймийн тул гадна, дотны ном нугууд гурван бодгаль түүний янагуухын ялдар үнэнээр эс бүтсэн хэмээн бүтээсэн мөн болой» хэмээн номлосон тул. Бас Тодорхой үгст-ээс янагуухад үнэн нь янагуухи үнэн хэмээн номлосон хийгээд “Хоёр үнэний өөрийн тайлбар”-аас «Ямар мэтээр үхэр адуулагч тэргүүтнээс дээшхи бээр үзэхүй тэр мэтээр янагуухад үнэнээр тийн орших буй за» хэмээн номлосон нь үнэнд баримтлах янагуухи оюуны ялдар үнэнд үйлдэх бөлгөө. “Бага бодь мөрийн зэрэг”-ээс «Тодорхой үгстээс, ертөнцийн янагуухад үнэн нь ертөнц янагуухи үнэн бөлгөө хэмээн номлосон нь Мадхьямакад орохуйн тайлбараас, янагуухи тэр бээр алин нэгэнийг үнэнд үзэх бөгөөд өвөрчлөн үгүйчлэнд өвөрчлөнд тус тус үзэх тэр нь ертөнц чанх буруу болсон янагуухад үнэн тул ертөнцийн янагуухи үнэн бөлгөө хэмээн урд номлосон мунхагын

янагуухи түүний ялдар үнэнд тодорхой номлосон мэтээр үйлдэх буй за, нэрийтгэлд үнэнээр бүтсэнд эс үйлдэх бөлгөө. Эс бөгөөс өөрийн бэлгэ чанараар бүтсэн нь нэрийтгэлд ч буй бусын ёс лугаа харшлахын учир хийгээд үнэнээр бүтсэнийг хорих ба үнэнээр үгүйг бүтээхийг нэрийтгэлд үйлдэхийн учир болой. Ёс үүгээр ачаръя Жнянагарбха бээр янагуухад үнэнээр оршмуй хэмээн номлосныг ч мэдэгдэхүй» хэмээн номлосон тул. Бас бус, Мадхьямакад орохуйн тайлбар-аас «Шүтээд болсон дүрс хөрөг хийгээд хадны цуурай тэргүүтэн өчүүхэн нэгэн нь худал /89 б/ боловч мунхаг лугаа төгөлдөр нүгүүдэд үзэгдэх амуй. Хөх тэргүүтэн дүрс хийгээд сэтгэл ба сэрэхүй тэргүүтэн өчүүхэн нэгэн нь үнэнээр үзэгдэх бөлгөө. Өвөрчлөн нь мунхаг лугаа төгөлдөр нүгүүдэд байдал бүхэнд үл үзэгдэх болой. Тиймийн тул тэр хийгээд алин нэгэн янагуухад ч худал нь янагуухын үнэн бус болой» хэмээн номлосны утгыг "Мадхьямакад орохуйн их тайлбар"-аас «Дүрс хөрөг тэргүүтэн нь худал боловч үзэгдэл нь худалаар үзэгдэх мөн бөгөөд тэр нь зүс царайд үзэгдэх хийгээд түүгээр хоосон хоёр чуулсан худал мөн тул түүний үнэнээр хоосон нь зүс царайд үнэнээр хоосон мөн буй за, дүрс хөрөг өөрийн бэлгэ чанараар бүтсэн үнэнээр хоосны утга үгүй болой. Тиймийн тул дүрс хөрөг нь зүс царайгаар хоосонд бүтэх ч дүрс хөрөг өөрийн бэлгэ чанараар бүтсэнд баримтлах янагуухын ялдар үнэн мөн дор харшлах юу ч үгүй бод мөн тул янагуухын үнэн мөн болой. Тиймийн учир дүрс хөрөг янагуухын үнэн бус хэмээн номлосон нь дохионд дадсан ертөнц янагуухын ялдар зүс царайны дүрс хөрөг мэт тэр зүс царай мөн тэр нь худал тул түүнээ дулдуйдсан янагуухын үнэн бус дор таалсан буй за, үзэх худал янагуухи үнэнд номлосон хэмээснээр номлосон янагуухи үнэнд эс талбих юунд мөн» хэмээснээс «Өвөрчлөн нь мунхаг лугаа төгөлдөр дор байдал бүхэнд үл үзэгдмүй хэмээн номлосон нь ч мунхагыг үл тэвчсэн хутагтан бээр тэр ямагт чанарыг илтэд онох хэмээн таалах учираас мунхагаар халдсан мэдэл дор таалсан амуй. Суралцагч хутагтын даган олохуйн бэлгэ билиг хийгээд эгэлийн тэр ямагт чанарын үзэл нүгүүд мунхаг ба /90 а/ түүний авъяасаар халдсан мөн тул илтэд үл үзэх боловч ер үнэмлэхүй үнэнийг үзнэ хэмээн таалах хэрэгтэй болой» хэмээн номлосон мэтээр мэдэх хэрэгтэй бөгөөд өчүүхэн нэгэн хэмээснийг Нагцо хэлмэрч бээр зарим нэгэн хэмээн хөрвүүлсэн мэтээр амар болой хэмээн номложихуй. Өвөрчлөн хэмээх нь мөн ёсны өвөрчлөн мөн бөгөөд тэр ямагт мунхаг хийгээд түүний авъяас алин нэгнээр халдсан мэдлийн ялдар тодорхой эс үзэгдэх хэмээн номлосон амуй. Даган олохуй бэлгэ билиг хэмээхийг суралцагч даган олохуйтын үндсэн дэх хоосон чанарыг бодтойяа онох оюун дор үйлдмүй.

Үргэлжлэл бий